



Хүчтэй. Хамтдаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

2017.4.23

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-йн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулж энгийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох
3. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-йн дүрмийн өөрчлөлтийг батлах тухай
4. Бусад асуудал

Ард Санхүүгийн Нэгдэл

Танилцуулга



Компанийн тухай

Эрхэм зорилго: Ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэржүүлэн барьснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд түвшинд барих бодлогыг мөрдөнө.

Алсын хараа: Бид хувьцаа эзэмшигчид болох ард иргэдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг дээдэлсэн Үндэсний хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани болно



Ердийн даатгал



Банк бус санхүүгийн
байгууллага



Хадгаламж зээлийн
хоршоо



Брокер, диллер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Хөрөнгө
оруулалтын менежмент



Тэтгэврийн сан



Шуудангийн
Цогц Шийдэл



Үл хөдлөх хөрөнгийн
түрээс



Санхүүгийн програм
хангамж



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
ҮНДЭСТЭН**

Хөрөнгө
оруулалтын сан

Ард Санхүүгийн Нэгдлийн үйл ажиллагааны тайлан

Онцлох үйл явдлууд



2016 оны онцлох үйл явдал



- **ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн** 4.26 хувийг худалдсаны төлбөр болох 6.2 сая доллар манай дансанд орж ирлээ. Тухайн үед 1 доллар 1,995 төгрөгтэй тэнцэж байв.
- Ард Санхүүгийн Нэгдэл **Монгол Шуудан ХК**-йн хувьчлалд оролцон 17.38 хувийг нь 3.2 тэрбум төгрөгөөр худалдан авлаа. Ард Санхүүгийн Нэгдэл нь нэмж **Монгол Шуудан ХК**-йн 13.01 хувийг Хишиг Арвин Индастриал ХХК-ас хувьцаа болон бэлэн мөнгө оролцуулан худалдан авч, оны эцэст Монгол Шуудан ХК-йн 31 хувийг эзэмшдэг боллоо. Энэхүү хэлцлийн дараа Х.Батхишиг нь 11.99 хувьтайгаар манай хамгийн том хувьцаа эзэмшигч болов.
- 2015 онд хийсэн хэлцлийн дагуу Ард Санхүүгийн Нэгдэл нь Ард Секюритиз ҮЦК-ар дамжуулан өөрийн 2 том хувьцаа эзэмшигчээсээ 20.1 хувийн хувьцааг 5.4 тэрбум төгрөгөөр худалдан авсан бөгөөд 2016 оны 1 сард төлбөрийг нь гүйцэтгэв. Энэ дүнг оруулаад 2016 онд нийт **11 тэрбум төгрөгийн хувьцааг** эргүүлэн худалдан авсан байна.
- **Хөрөнгө Оруулагч Үндэстэн** хөдөлгөөнийг эхлүүлж, оны эцэст компани нь хаалттай хувьцаат компани болж чадсан юм. Жинст Увс ХК-тай нэгдэхтэй холбоотой бичиг баримтыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүллээ.



2016 оны онцлох үйл явдал



• Ард Холдингс **Ард Кредит ББСБ**-д 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн ба жижиг хувьцаа эзэмшигчээс 12.7 хувийг худалдан авч өөрийн эзэмшлээ 80.7 хувьд хүргэлээ.



• Ард Секюритиз ҮЦК-ийн тусламжтайгаар бид нийт 14.2 тэрбум төгрөгийн Ард Санхүүгийн Нэгдлийн **хувьцааг арилжсан** байна.




• **Ард Секюритиз нь** хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ болон брокер, дилер, андеррайтерын үйлчилгээний эрхээ хадгалан ажиллахад нь зориулан 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийв.

• Ард Санхүүгийн Нэгдэл Ард Актив дээр байсан тэтгэврийн үйлчилгээг тусгаарлан **Ард Лайф** буюу хуучнаар МТНД-д шилжүүллээ.




• Ард Санхүүгийн Нэгдэл нь **ТТДС**-ийн 50 хувийг 9.8 тэрбум төгрөгөөр тооцож, удирдлагын багт нь худалдлаа. Уг хэлцлийг урт хугацааны зээл, үл хөдлөх хөрөнгө болон хувьцаа солилцоогоор санхүүжүүлсэн юм.



2016 оны онцлох үйл явдал



- **Ард Менежмент** компани хөрөнгө оруулалтын сангийн менежментийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авав.



- Ард Санхүүгийн Нэгдэл нь **Ард Даатгалын** жижиг хувьцаа эзэмшигчдээс компанийн 30 хувийг худалдан авч өөрийн эзэмшлээ 85 хувьд хүргэлээ. Тус компанийн 2 хувийг Хөрөнгө Оруулагч Үндэстэн эзэмшиж байна.



- Бид Ард Секюритиз ҮЦК-йн андеррайтинг хийсэн Хүннү Эйр компанийн 600,000 долларын бондыг амжилттайгаар босгон өглөө.

- Ноён Бруно Рашле нэмж 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийв.



HUNNU
AIR

- Оны эцэс гэхэд бид нийт хувьцаа эзэмшигчдийнхээ тоог 10 дахин өсгөж 3,000-д хүргэн Монгол Улсын 1,000 иргэн тутмын 1 нь Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигч болсон томоохон үйл явдал тохиолоо.

Ард Санхүүгийн Нэгдлийн санхүүгийн тайлан

2016 ОН ТООГООР




2016 ОН ТООГООР


Өөрөөр заагагүй бол сая төгрөгөөр	2015	2016	Өөрчлөлт
Нийт Хөрөнгө	40,759	39,392	-3%
Зээлийн Багц	1,824	5,360	194%
Үндсэн Хөрөнгө	862	676	-22%
Эздийн Өмч	34,783	37,466	8%
Нийт Өр Төлбөр	5,976	1,946.4	-67%
Цэвэр Ашиг	174	3,453.8	
Нийт Орлого	12,695	12,455	-2%
Нэгдлийн Нийт Хөрөнгө	36,431	40,089	МЭ
Нэгдлийн Нийт Ашиг	10,224	7,222	ГЗ
Эргэлтэнд Буй Нийт Хувьцаа	13,486,35	14,151,45	5%
Нэгж Хувьцааны Өгөөж (Төгрөг)	13	244.05	307%
Нэгж Хувьцааны Үнэлгээ (Төгрөг)	2,176	2,453	13%

Үзүүлэлт


Цэвэр ашиг



Зээлийн багц



Нэгж хувьцаанд
ноогдох ашиг



Нэгж хувьцааны үнэлгээ



Төлөөлөн удирдах зөвлөл

Одоогийн бүтэц



ТУЗ-ийн бүтэц

ТУЗ-ийн гишүүд:

Жанчивын Оюунгэрэл

Луна энд Луна ХХК
Гүйцэтгэх захирал
1,450,801

Хутагч Ч.Ганхуяг

Ард Санхүүгийн Нэгдэл ХК
Гүйцэтгэх захирал
1,132,000

Хишигдоржийн Батхишиг

Хишиг Арвин Индастриал ХХК
Гүйцэтгэх захирал
1,689,415

Бруно Рашле

АДВЕК Нэгдэл AG ТУЗ-ийн дарга
1,302,016

Антони Хоброу

ВенчурсУан Гүйцэтгэх захирал
1,304,043

Одончимэдийн Одбаяр

Мон Интернэйшнл
Гүйцэтгэх захирал
452,000

Лхагвасүрэнгийн Соронзонболд

ХХБ Орлогч захирал, Хараат бус гишүүн
306,710

Цогбадрахын Ариунтөгс

Монголын Алт (МАК) ХХК Хөрөнгө оруулалт,
эрсдэлийн удирдлагын газрын захирал
873,000

Пүрэвжаргалын Батбаяр

Резилиенс Майнинг ТУЗ-ийн гишүүн
11,000

Галбадрахын Цогбадрах

Хараат бус гишүүн
74,890

Ванданцэрэнгийн Баяржаргал

Интергрупп Интернэйшнл ХХК
Гүйцэтгэх захирал
917,333

ТУЗ-ийн хороод:

Засаглал, Цалин урамшуулал,

Нэр дэвшүүлэх хороо

Р. Бруно (Хорооны дарга)

П. Батбаяр

О. Одбаяр

Х.Батхишиг

Аудитын хороо

Ц. Ариунтөгс (Хорооны дарга)

Л. Соронзонболд

Х. Антони

Хөрөнгө Оруулалт, Санхүү, Эрсдлийн хороо

П. Батбаяр (Хорооны дарга)

В. Баяржаргал

Г. Цогбадрах

Х. Антони

Ч. Ганхуяг

Төлөөлөн удирдах зөвлөл

Ердийн гишүүнд нэр дэвшигчид



Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр :Жанчив

Өөрийн нэр : Оюунгэрэл

Төрсөн огноо : 1955.03.04

Боловсрол : Дээд

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэлийн
ТУЗ-ийн дарга



Хоёр. Боловсрол

Улаанбаатар	Нийслэлийн лаборатори 1-р дунд сургууль		
ОХУ	Москва хотын Губкины нэрэмжит Нефть химийн дээд сургууль	Нефтийн инженер – эдийн засагч	Эдийн засгийн ухааны доктор

Гурав.Ажлын туршлага

Петровис ХХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	2008	-
Петро Матад ХХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гүйцэтгэх бус захирал	2007	2010
Энержи Ресурс ХХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн	2008	2010
ММС ХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гүйцэтгэх бус захирал	2010	-
Петро Матад ХХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэд дарга	2012	2013
Петро Матад ХХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	2013	-
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	2014	-

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр: Чулуун

Өөрийн нэр: Ганхуяг

Төрсөн огноо: 1973/11/20

Боловсрол: Дээд

Мэргэжил: Эдийн засагч, Банк санхүүгийн менежмент

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал



Боловсрол

Унгар	Budapest University of Economic Sciences	Эдийн засагч	Бакалавр
АНУ	Stonier/ABA	Мэргэжил дээшлүүлэх сургалт	-
АНУ	Shore bank		-
АНУ	Бүтээлч Манлайлалын төв	Манлайлалын хөтөлбөр	-
АНУ	Харвард Кеннеди Их Сургууль	21-р зууны Дэлхийн Манлайлал ба Олон нийтийн бодлого	-

Гурав.Ажлын туршлага

ХасБанк	Гүйцэтгэх захирал	1998	2009
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл	Гүйцэтгэх захирал	2009	2010
Сангийн Дэд сайд	Сангийн Дэд сайд	2010	2012
И Ай Ти ХХК	ТУЗ-ийн Дарга	2012	2014
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Гүйцэтгэх захирал	2014	Одоо

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр: Рашле

Өөрийн нэр: Бруно

Төрсөн огноо: 1950

Боловсрол: Дээд

Мэргэжил: Барилгын инженер, үйлдвэрийн инженер

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл

ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Боловсрол

Швейцар	Швейцар Улсын Их Сургууль		Бакалавр
Швейцар	Швейцар Улсын Технологийн Их Сургууль	Барилгын инженер	Мастер
Америк	Стэнфорд Их Сургууль	Үйлдвэрийн инженер	Мастер
Америк	Харвардын Их Сургууль	Дээд түвшний менежментын программ	

Гурав.Ажлын туршлага

Хэйек Инженеринг Эй Жи	Төслийн инженер	1980	1982
Мотор-Колумбус Эй Жи	Гүйцэтгэх захирал	1983	1993
Баллард Повер Системс	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн	1989	1997
Эс Эп Эс Стэдлер компани	Гүйцэтгэх захирал	1997	Одоо

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр: Хоброу

Өөрийн нэр: Энтони

Төрсөн огноо: 1955/07/18

Боловсрол: Дээд

Мэргэжил: Мэргэшсэн нягтлан бодогч

Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл
ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Боловсрол

ЮБУИНВ

Бристол Их Сургууль

Эдийн засагч

Бакалавр

Гурав.Ажлын туршлага

Прайс Уотерхаус	Аудитын менежерын туслах	1977	1983
Энглиш энд Американ Групп	Үйл ажиллагаа эрхэлсэн захирлын	1983	1993
Виттингтон Групп	Гүйцэтгэх захирал	1989	1997
Венчурс Уан Би Ви	Нэгдлийн захирал болон Азийн бүсийг	2006	-
Дайрект Эйшиа Групп	Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга	2010	-

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр: Цогбадрах

Өөрийн нэр: Ариунтөгс

Төрсөн огноо: 1985/12/05

Боловсрол: Дээд

Мэргэжил: Олон улсын бизнесийн удирдлага

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Ард Санхүүгийн Нэгдэл
ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Боловсрол

Австри	Дунд сургууль		
Австри	Венагийн Бизнесийн Их Сургууль	Олон улсын бизнесийн удирдлага	Бакалавр
Австри	Венагийн Бизнесийн Их Сургууль	Бизнесийн Удирдлага	Магистр

Гурав.Ажлын туршлага

Юу Пи Си Телекабель ХХК	Худалдааны төлөөлөгч	2006	2009
Ди Пи Эс Софтвэйр ХХК	Маркетинг, худалдааны дарга	2009	2010
Деллойте Аудит Сервис	Ахлах Аудитор	2011	2014
МАК ХХК	Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн	2015	-

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Чинбат

Өөрийн нэр : Номин

Хүйс :Эмэгтэй

Төрсөн огноо : 1983

Боловсрол : Дээд

Мэргэжил : Санхүү, эдийн засагч



Боловсрол

Англи

East Anglia

Санхүү, эдийн засагч

Бакалавр

Гурав.Ажлын туршлага

Гацуурт ХХК	Гадаад харилцааны менежер	2003	2006
Тэрэлж Сүйх ХХК	Захирал	2006	
Монгол ТВ	Гүйцэтгэх захирал	2011	

Төлөөлөн удирдах зөвлөл

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид



Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Одончимэд

Өөрийн нэр : Одбаяр

Төрсөн огноо : 1966.08.12

Боловсрол : Дээд

Мэргэжил : Багш, Хуульч

Хоёр. Боловсрол



Боловсрол

ЗХУ	Багшийн Их Сургууль	Багш	Бакалавр
Монгол	Отгонтэнгэр Их Сургууль	Хуульч, Эрх зүйч	Бакалавр

Гурав.Ажлын туршлага

УБДС	Багш	1988	1992
МИАТ ХК Бээжин дэх төлөөлөгчийн газар	Менежер	2002	2005
Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ	Атташе, 3-р нарийн бичгийн дарга, Консул	2005	2010
Засгийн газар	МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх	2010	2012
Алтай Холдинг	Дэд ерөнхийлөгч	2012	Одоо

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Пүрэвжаргал

Өөрийн нэр : Батбаяр

Төрсөн огноо : 1976.11.06

Боловсрол : Дээд

Мэргэжил : Эдийн засагч, Санхүүч

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Resilience Mongolia Mining Pty
ТУЗ-ийн гишүүн



Боловсрол

ЗХУ	Багшийн Их Сургууль	Багш	Бакалавр
Монгол	Отгонтэнгэр Их Сургууль	Хуульч, Эрх зүйч	Бакалавр

Гурав.Ажлын туршлага

Resilience Mongolia Mining Pty	ТУЗ-ийн гишүүн	2015	-
Хаан Банк	Байгууллагын Банкны захирал	2014	2015
Интер Групп ХХК	ТУЗ-ын дарга	2011	2014
Scedrock Mongolia LLC	Гүйцэтгэх захирал	2010	2013
ЕСБХБ, Лондон хот	Natural Resources Banker	2001	2010
Сангийн яам	Эдийн засагч	2000	2001

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Пүрэвжаргал

Өөрийн нэр : Батбаяр

Төрсөн огноо : 1976.11.06

Боловсрол : Дээд

Мэргэжил : Эдийн засагч, Санхүүч

Одоо эрхэлж байгаа албан тушаал: Resilience Mongolia Mining Pty
ТУЗ-ийн гишүүн



Боловсрол

А в с т р а л и , Мельбурн	Мельбурнийн Их Сургууль	Худалдааны удирдлага	Магистр
Улаанбаатар	МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль	Санхүүгийн удирдлага – Банкны менежмент	Бакалавр

Гурав.Ажлын туршлага

ХОТШ	Маркетингийн менежер	1997	1999
НҮБХХ-Микростарт Монгол	Салбарын зохицуулагч	1999	1999
Хөгжлийн Алтан Сан	Менежер	1999	2002
ХасБанк	Гүйцэтгэх Тэргүүн Дэд захирал	2002	2011
Худалдаа Хөгжлийн Банк	Гүйцэтгэх захирлын орлогч	2011	-
Сангийн яам	Эдийн засагч	2000	2001

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Нармандах


Өөрийн нэр : Мөнхнасан

Хүйс :Эмэгтэй

Төрсөн огноо : 1981.03.26

Боловсрол : Дээд

Мэргэжил : Санхүүгийн инженер, эдийн засагч



Боловсрол

АНУ	Жорж Вашингтоны Их Сургууль	Санхүүгийн инженер, эдийн засагч	Магистр
АНУ	Сан Францискогийн Их Сургууль	Санхүүгийн инженер, эдийн засагч	Баклавр

Гурав.Ажлын туршлага

Монгол Банк	Ахлах эдийн засагч	2003	2006
Дэлхийн банк, АНУ	Эдийн засагч	2008	2012
ANN ХХК	Үүсгэн байгуулагч/Ерөнхий захирал	2006	
Монполимет	Ерөнхий захирал	2012	
Монголын Бизнесийн зөвлөл ТУЗ	ТУЗ-ийн гишүүн	2016	
МХАҮТ-н Япон Монголын Бизнесийн Зөвлөл	Тэргүүлэгч	2017	

Товч танилцуулга

Эцэг /эх/-ийн нэр : Галбадрах

Өөрийн нэр : Цогбадрах

Төрсөн огноо : 1975/02/05

Боловсрол : Дээд

Мэргэжил : Санхүүч, эдийн засагч

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д эрхэлж байгаа албан тушаал :

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Боловсрол

Монгол	МУИС-ын Эдийн Засгийн Сургууль	Банкны эдийн засагч	Бакалавр
АНУ	Үндэсний Их Сургууль	Бизнес удирдлага	Мастер

Гурав.Ажлын туршлага

Голомт Банк	Гадаад төлбөр тооцооны нягтлан бодогч	1996	1997
Хас Банк	Санхүү, Дотоод аудит, Салбарын удирдлага, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал	2000	2008
Тэнгэр Санхүүгийн Нэгдэл	Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2010	2011
Тэнгэр Даатгал	Гүйцэтгэх захирал	2011	2014
Ард Санхүүгийн Нэгдэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2014	-

Дүрмийн нэмэлт, өөрчлөлт

Төсөл



Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
1.1	“АСН ХХК” гэснийг	“Ард Санхүүгийн Нэгдэл ХК” гэж өөрчлөх;
1.5	“Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу /14200/, Б.Алтангэрэлийн гудамж 5, Ш/Хаяг 210646/УБ 46, Сити Центр барилгын 403 тоот”	“Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхар” гэж өөрчлөх;
4.3	“Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ”	Хүчингүй болсонд тооцох;
4.4	“Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, дэд захирал, хэлтэс, албаны дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна” гэснийг	“Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү хариуцсан захирал, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал, Дотоод аудитор, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн арийн бичгийн дарга нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах
5.4.9		“Хувьцаа эзэмшигч нь улирал бүр компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй” гэж нэмэлт оруулах 5.4.9 дүгээр заалт нь 5.4.10 дахь заалт болж өөрчлөгдөнө.

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
6.1	“Хувьцаа эзэмшигчид энэхүү дүрэмд хавсаргасан Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд тусгасан байдлаар хувьцаа эзэмшинэ” гэснийг	“Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.8-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ” гэж өөрчлөх
6.7	“Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 2 жил хүртэлх хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ...” гэснийг	Хүчингүй болсонд тооцох
6.8	“Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 2-оос дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг ...” гэснийг	Хүчингүй болсонд тооцох
7.3	“Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь “Хувьцаа эзэмшигчдийн зарлан хуралдуулах журам”-ыг баталж мөрдүүлнэ” гэснийг	“ТУЗ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх, хяналт тавих журам”-ыг баталж мөрдүүлнэ” гэж өөрчлөлт оруулах
7.12		“... Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна” гэж нэмэлт оруулах
8.2	“Компанийн ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байна. ...” гэснийг	“Компанийн ТУЗ нь 9-өөс 11 гишүүнтэй байна. ... ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээр бүрдэнэ” гэж өөрчлөлт оруулах
8.4	“...ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн үүрэг гүйцэтгэнэ” гэснийг	“...ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ” гэж өөрчлөлт оруулах

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
8.4.2	“ТУЗ-ийн дарга нь үйл ажиллагааны журмаар тогтоосон өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх, компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулах эрхтэй байна” гэснийг	Хүчингүй болсонд тооцох
8.10	“ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна” гэснийг	“ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана” гэж нэмэлт, өөрчлөлт оруулах
8.12	-д	“5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд томилох эрхтэй бөгөөд өөрийн томилсон этгээдийг ТУЗ-ийн бүрэлдэхүүнд томилох эрхтэй” гэж нэмэлт оруулах
8.13	-т	“ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд: 8.13.1 компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах, 8.13.2 ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна, 8.13.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх, 8.13.4 ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, өөрийн мэдлэг чадвар, нөөц бололцоог дайчлан ажиллах, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнаж ажиллах үүрэгтэй” гэж нэмэлт оруулах

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
8.14		“Компани шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудитын хороо 2. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, 3. Хөрөнгө оруулат, санхүү, эрсдэлийн хороог тус тус байгуулан ажиллуулна” гэж нэмэлт оруулах
8.15		“8.15. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд: 8.15.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих; 8.15.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах; 8.15.3. Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, 8.15.4 Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх (чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ); 8.15.5. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах; 8.15.6. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг” гэж нэмэлт оруулах

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
8.16	-д	“8.16. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ: 8.16.1. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох; 8.16.2. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд энэхүү дүрмийн 8.13-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх; 8.16.3. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх; 8.16.4. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх; 8.16.5. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах; 8.16.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах; 8.16.7. Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах; 8.16.8. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих; 8.16.9. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих; ”

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн	Одоо байгаа хүчин төгөлдөр	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
8.17	-д	8.17 Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 8.17.1 Компанийн стратеги төлөвлөгөөг судалгааны үндсэн дээр боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах; 8.17.2 Санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөнд нийцсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, шинээр хийгдэх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд стратегийн эрсдлийн урьдчилан дүгнэлт гаргах, чиглэл, зөвлөмж боловсруулах; 8.17.3 Компанийн үнэ цэнийг тодорхойлж, хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, хамгаалахад чиглэсэн бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах; 8.17.4 Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ хэлцэлүүд, компанийн өөрчлөн байгуулалт (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах г.м) зэрэгт хяналт тавьж ажиллана; 8.17.5 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг” гэж нэмэлт оруулах
8.18	...	“ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд 3 болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд дараалан биеэр оролцоогүй мөн аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй” гэж нэмэлт оруулах

Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Дүрмийн зүйл, заалт	Одоо байгаа хүчин төгөлдөр дүрэм, дүрмийн зүйл заалт	Нэмэлт өөрчлөлтийн төсөл
9.8	-Д	“Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана” гэж нэмэлт оруулах
11.5	“...шалгалт хийлгэх зорилгоор аудитыг сонгож...” гэснийг	“...шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллага сонгож” гэж өөрчлөлт оруулах
11.6	“Гэрээнд компанийн бололн аудиторын эрх, үүрэг...” гэснийг	“Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг...” гэж өөрчлөлт оруулах
11.7	“Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудорын шалгалт нь ...” гэснийг	“Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ...” гэж өөрчлөлт оруулах
11.9	“Дараах этгээдийг компанийн аудиторoor ...” гэснийг	“Дараах этгээдийг компанийн Дотоод аудитор болон аудитын байгууллагаар...” гэж өөрчлөлт оруулах

Санал хураалт

